



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 1502

Арвайхээр

**Тендерийн гүйцэтгэгчийг сонгох,
тендер хүчингүй болгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 30 дугаар зүйлийн 30.1.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 82 дугаар дүгнэлтийн дагуу Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, шинэчлэл (Өвөрхангай, Арвайхээр сум) ажлын 13 дугаар багц Спортын ордон, усан спорт сургалтын төвийн авто зогсоолыг 265000000 (хоёр зуун жаран таван сая) төгрөгөөр Өвөрхангай-АЗЗА ТӨХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Шаардлага хангасан нэг ч тендер ирээгүй 14 дүгээр багц Нийтийн эзэмшлийн талбайд ус үл нэвтрэх доторлогоотой нүхэн бие засах газар байгуулах, 15 дугаар багц Пүрэвдоржийн цэцэрлэгт хүрээлэн, Аюушбаатарын хөшөөний тохижилт, 16 дугаар багц Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайн усалгааны тоног төхөөрөмж нийлүүлэх зэрэг багцуудыг хүчингүй болгож, худалдан авах ажиллагааг дахин зохион байгуулсугай.

3. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.

4. Дээрх хүчингүй болсон багцуудыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар дахин зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100881